



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/663

Ховд


Жуух бичгээр шагнах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “А” дахь заалт, аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн “Е”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.8, 3.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эх орон, ард түмнийхээ төлөө өргөсөн тангарагтаа үнэнч байж, албан үүргээ нэр төртэй гүйцэтгэн, хамт олноо манлайлан, олон жил үр бүтээлтэй ажиллаж буй шийдвэр гүйцэтгэгч, ахлах дэслэгч З.Лхагвадорж, ээлжийн дарга, ахлах дэслэгч Г.Энхтайван, шийдвэр гүйцэтгэгч, ахлах дэслэгч Г.Саран, ахлах нягтлан бодогч, ахлах дэслэгч М.Нурханат, дэслэгч П.Дашцэдэн, ахлах ахлагч Л.Цэвээндарь нарыг аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан албан хаагчдад 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга /дэд хурандаа Б.Эрдэнэбат/, нягтлан бодогч /ахлах дэслэгч М.Нурханат/ нарт зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 2596
Zah A/663 Kh